

Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэлтийн индекс 2017 судалгааны тайлангаас Монгол улсын 2017 оны гадаад худалдаатай холбоотой үзүүлэлтүүдийг танилцуулж байна. Дэлхийн банкнаас гаргадаг бизнес эрхлэлтийн индекс нь бизнес шинээр эхлүүлэх, барилгын зөвшөөрөл авах, цахилгаан эрчим хүчийг авах, үл хөдлөх хөрөнгийг бүртгүүлэх, зээл авах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, татвар төлөлт, хилийн дагуух худалдаа, гэрээг биелүүлэх, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх болон хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт зэрэг 10 гаруй шалгуур үзүүлэлтүүдээр тухайн улсын

бизнес эрхлэх орчныг дүгнэж гаргадаг томоохон судалгаа юм. Тус судалгаанд дэлхийн 190 орныг голлох үзүүлэлтүүдээр эрэмбэлсэн бөгөөд ингэхдээ улсын хил хүртлэх зайн үзүүлэлт болон бизнес эрхлэх түвшинг хөнгөвчилсөн байдал гэсэн 2 аргаар үр дүнг тайлагнан харуулсан байна. 2017 оны байдлаар Монгол улс бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн 190 орноос 64 дүгээр байрт жагссан байна. Энэ нь өмнөх 2016 оныхтой харьцуулахад 2 байраар ухарсан хэрэг юм.

Бизнес эрхлэлтийн индекс 2017/2016 харьцуулалт:


№	Үзүүлэлт	2017 он	2016 он	Өөрчлөлтийн үзүүлэлт
1	Бизнес шинээр эхлүүлэх	36	32	4 буурсан
2	Барилгын зөвшөөрөл авах	29	26	3 буурсан
3	Цахилгаан эрчим хүчийг авах	137	136	1 буурсан
4	Үл хөдлөх хөрөнгийг бүртгүүлэх	46	45	1 буурсан
5	зээл авах	62	60	2 буурсан
6	хөрөнгө оруулагчдыг хамгаалах	26	22	4 буурсан
7	татвар төлөлт	35	73	38 өссөн
8	хилийн дагуух худалдаа	103	102	1 буурсан
9	гэрээг биелүүлэх	85	83	2 буурсан
10	төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх	91	87	4 буурсан

Эх сурвалж: <http://www.doingbusiness.org>

Өнгөрсөн онтой харьцуулахад бизнес эрхлэлтийн индексийн бүхий л үзүүлэлт буурсан харагдаж байна. Өөрөөр хэлбэл татвар төлөлтийн

үзүүлэлтээс бусад нь бүгд бизнесийн орчин муутай байна гэсэн үг юм. Татвар төлөлтийн индекс харин нэлээд байраар дээшилсэн байна.

Бүс нутгийн үзүүлэлтийг харвал:



Эх сурвалж: <http://www.doingbusiness.org>


Дээрх судалгааны үр дүнгээс харахад Монгол улс бизнесийн үйл ажиллагаа явуулахад бизнес эрхлэлтийн үзүүлэлт бүс нутгийн хэмжээнд нэлээд доогуур байр эзэлсэн байгаа нь манай улсын

Хилийн дамнасан худалдааны үзүүлэлт

Дэлхийн банкны хил дамнасан худалдааны үзүүлэлтээр харахад манай улс 2017 оны байдлаар 103 дугаар байрт жагссан байна. Тус үзүүлэлт нь тухайн улсын гадаад худалдааны гол хилийн боомтууд дээр худалдааны үйл

хувьд улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, бизнесийн таатай орчин сайн бүрдэж чадаагүй, тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээлүүд байсаар байгааг илтгэж байна.

ажиллагаанд хир хүндрэл гардаг, мөн хилийн худалдааны орчин хир байгааг дүгнэхэд чиглэдэг. 2016 онд 74 дүгээр байрт орж байсан тус үзүүлэлт



Эх сурвалж: <http://www.doingbusiness.org>

Графикаас Монгол улс Бүс нутгийн хэмжээд хил дамнасан худалдааны үзүүлэлтээр дундаж үзүүлэлттэй байна. Харьцуулалтаас харахад манай улсын хууль тогтоомж, хилийн хяналт болон авто зам, төмөр замын дэд бүтэц буюу

тээвэр логистикийн бүтцийн сул хөгжил, гааль, мэргэжлийн хяналт, гадаад худалдааны бусад хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хүнд суртал голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.

Дараагийн тоо баримт нь Монгол улсын хил дамнасан худалдааны экспорт, импортын цаг хугацаа зардлын үзүүлэлтийг харуулж байна. Тус судалгааг

дотоодын тээвэр зуучид, гаалийн зууч болон худалдаа эрхлэгчдээс авч, тэдний мэдээлэлд тулгуурлан нэгдсэн дүгнэлтийг гаргасан байна.

	Монгол улс	Зүүн Ази болон Номхон далайн Бүс нутаг
Экспортын цаг хугацаа: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цагаар/	62	57
Экспортын зардал: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам.доллараар/	191	402
Экспортын цаг хугацаа: Бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цагаар/	168	73
Экспортын цаг хугацаа: Бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам.доллараар /	64	132

Импортын цаг хугацаа: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цагаар/	48	71
Импортын зардал: Хил дээрх зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /ам.доллараар/	210	436
Импортын цаг хугацаа: Бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан /цагаар/	115	71
Импортын цаг хугацаа: Бичиг баримтын зөвшөөрөл авах үйл ажиллагаа багтсан / ам.доллараар /	83	128

Эх сурвалж: doing business database

Монгол улсын хилээр гарч буй экспорт, орж ирж буй импортын бараа бүтээгдэхүүнд зөвшөөрөл авах хугацаа, зардлын хувьд харьцангуй боломжийн үзүүлэлт харагдаж байна. Харин экспорт импортын бичиг баримттай холбоотой зөвшөөрөл авах хугацаа, зардлын хувьд харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь Монгол улс нь гадаад худалдаанд бүрдүүлж буй бичиг баримтын цаг хугацаа, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийх шаардлагатай нь харагдаж байна. Далайд гарцгүй манай улсын хувьд

нийт 46 хилийн боомт байгаагийн 29 нь ОХУлстай, 13 нь БНХАУлстай хиллэж байна. Эдгээрээс 14 нь олон улсын, 11 нь байнгын ажиллагаатай, 14 нь түр, 7 нь дамжин өнгөрүүлэх боомтууд байна. БНХАУлстай хиллэж байгаа 13 хилийн боомтын хамгийн чухал ач холбогдолтой боомт нь Замын Үүдийн боомт юм. Хил дамнасан худалдаанд тодорхой бараа бүтээгдэхүүнийн хувьд тээврийн хугацаа болон бичиг баримтанд зарцуулж буй хугацаа, зардлыг нарийвчилан үзвэл:

	Экспорт	Импорт
Бүтээгдэхүүн	HS 51 : Ноос, нарийн болон бүдүүн ширхэгтэй амьтны үс; адууны үс, нэхмэлийн утас болон нэхмэл даавуу	HS 8708: Автомашины сэлбэг, эд анги
Худалдааны түнш орон	БНХАУ	БНХАУ
Хилийн цэг	Замын Үүдийн хилийн цэг	Замын Үүдийн хилийн цэг
Зай (км)	890	890
Дотоодын тээврийн хугацаа (цагаар)	27	27
Дотоодын тээврийн зардал (ам.доллараар)	594	594
Дотоодын тээврийн хурд (км /цагаар)	32,6	32,6
Дотоодын тээврийн зардал зай тутам (ам.доллар/км)	0,7	0,7

Эх сурвалж: doing business database

Хүснэгтээс харахад өмнөх он үзүүлэлтээс өөрчлөгдсөн зүйл байхгүй байна. Экспортын бараа бүтээгдэхүүн ч бай, импортын бараа бүтээгдэхүүн ч бай Замын Үүдийн хил хүртлэх дотоодын тээврийн зардал, хугацаа ижил байна.

Гэвч хилийн цэг дээрх зөвшөөрөл лиценз болон бичиг баримттай холбоотой хугацаа, зардлын хувьд өндөр үзүүлэлт гарч байгаа нь хил дамнасан худалдааны хувьд гол асуудал нь болж байна.



**Монгол улсын гадаад худалдаанд хэрэглэгддэг
бичиг баримтуудын судалгаа**

№	Экспортын үйл ажиллагаа	Импортын үйл ажиллагаа
1	Гарал үүслийн гэрчилгээ	Гарал үүслийн гэрчилгээ
2	Үнийн нэхэмжлэх	Үнийн нэхэмжлэх
3	Экспортын гаалийн мэдүүлэг	Импортын гаалийн мэдүүлэг
4	Сав баглаа боодлын жагсаалт	Сав баглаа боодлын жагсаалт
5	Эрүүл ахуй ариун цэврийн зөвшөөрөл	Худалдааны гэрээ
6	Тохирлын гэрчилгээ	
7	Худалдааны гэрээ	
8	Экспортын зөвшөөрөл	

Эх үүсвэр: Дэлхийн банк, Бизнес эрхлэлтийн индекс 2016

Дэлхийн банкны Бизнес эрхлэлтийн индекс 2017 тайланд экспорт, импортын бичиг баримтын тоо өмнөх жилүүдийн судалгаанд дурдагсанаас өөрчлөгдсөн буюу бичиг баримтын тоо нэмэгдсэн дүр зурагтай байна. 2015, 2016 онуудын байдлаар экспорт, импортын худалдаанд тээврийн бичиг баримт, нэхэмжлэл, гаалийн мэдүүлгээс гадна гаалийн байцаагчид сав баглаа боодлын жагсаалт, гэрээ, лабораторын шинжилгээний дүгнэлт, төлбөрийн баримтууд, даатгалын гэрчилгээ, барааны гарал үүслийн гэрчилгээ, хөдөө аж ахуйн биржийн бичиг баримтуудыг нэмж шаардаж байсан билээ.

Экспорт болон импортонд шаардагдах бичиг баримтын тоог цөөрүүлэх зорилгоор 2012 онд “Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйл”-д орсон өөрчлөлт оруулсан ч бодит байдалд шаардлагатай бичиг баримтын тоо жил бүр өөрчлөгдөж байна. Энэ нь тухайн бараа бүтээгдэхүүний онцлогоос шалтгаалж байгаа төдийгүй зарим тохиолдолд худалдаа хийж буй орны шаардлагаас ч хамаарч байна.



Экспортын худалдаанд хилээр гарах үеийн шаардлагын хувьд зардал өндөр боловч хугацаа бага, бичиг баримтын шаардлагын хувьд зардал бага боловч хугацаа их шаардагдаж байна. Харин

импортын худалдаанд хилээр орох үеийн шаардлагын хувьд зардал өндөр хугацаа бага шаардаж байхад бичиг баримтын шаардлагын хувьд зардал бага хугацаа их шаардагдаж байна. Үүнээс үзэхэд бичиг

баримтыг хурдан шуурхай бүрдүүлэх, зөвшөөрөл авах зэрэгт зарцуулах хугацааг бууруулахын тулд бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох байгууллагууд хоорондоо онлайн хэлбэрт шилжих хэрэгцээ шаардлага харагдаж байна. Энэ нь эргээд

худалааг хөнгөвчлөх цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх, худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг бодит байдалд хэрэгжүүлэх, тээврийг хөнгөвчлөх асуудлыг яаралтай шийдвэрлэх гэх мэт олон үйл ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй харуулж байна.